



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 15 (348)

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Иргэний хамгаалалтын тусламжийн тухай конвенцид нэгдэн орсныг соёрхон батлах тухай*

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Авто тээврийн хэрэгслийг үзлэгт оруулах хугацаа, оношлогооны төлбөрийн жишиг батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2004 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2004 оны дөрөвдүгээр сарын 21 №15 (348)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- |      |  |     |
|------|--|-----|
| 177. | Иргэний хамгаалалтын тусламжийн тухай конвенцид нэгдэн орсныг соёрхон батлах тухай | 301 |
| 178. | Хэлэлцээрт оруулсан нэмэлт өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, соёрхон батлах тухай       | 302 |

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- |      |                                      |           |     |
|------|--------------------------------------|-----------|-----|
| 179. | Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай | Дугаар 45 | 302 |
|------|--------------------------------------|-----------|-----|

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- |      |   |           |     |
|------|---|-----------|-----|
| 180. | Авто тээврийн хэрэгслийг үзлэгт оруулах хугацаа, оношлогооны төлбөрийн жишиг батлах тухай | Дугаар 55 | 302 |
| 181. | Хэлэлцээр батлах тухай  | Дугаар 56 | 303 |
| 182. | Үйл ажиллагааны чиглэл батлах тухай   | Дугаар 57 | 303 |
| 183. | Хэлэлцээр батлах тухай  | Дугаар 58 | 313 |
| 184. | Засгийн газрын үйл ажиллагааны мэдээлэл, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх тухай           | Дугаар 59 | 313 |
| 185. | Хэлэлцээр батлах тухай  | Дугаар 60 | 314 |
| 186. | Малын гоц халдварт шүлхий өвчний талаар авах арга хэмжээний тухай                         | Дугаар 65 | 314 |

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр

Улаанбаатар хот

### ИРГЭНИЙ ХАМГААЛАЛТЫН ТУСЛАМЖИЙН ТУХАЙ КОНВЕНЦИД НЭГДЭН ОРСНЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл, Швейцарь Улсын Женев хотноо 2000 оны 5 дугаар сарын 22-ны өдөр баталсан Иргэний хамгаалалтын тусламжийн тухай Конвенцид Монгол Улс нэгдэн орсныг соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН  
ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

### ХЭЛЭЛЦЭЭРТ ОРУУЛСАН НЭМЭЛТ, ӨӨЧЛӨЛТИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ, СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Европын сэргээн босголт, хөгжлийн банк үүсгэн байгуулах хэлэлцээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч,

соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭДДАРГА Ж. БЯМБАДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр

Дугаар 45

Улаанбаатар хот

### Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

#### ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 41 дүгээр зарлигаар батлагдсан "Цэргийн цол олгох журам" -д дараахь нэмэлт, өөрчлөлт оруулсугай:

1. Журмын 4 дэх хэсэгт "2<sup>1</sup> Дээд офицерыг цэргийн жинхэнэ албанаас чөлөөлөх, цэргийн жинхэнэ албанд эргүүлэн авах, дээд офицерын цолны зэрэглэлгүй албан тушаалд томилсон цэргийн цол бууруулах, дээд офицерын цэргийн цолыг хасах буюу сэргээн олгох бол энэ тухай саналаа дээд офицерын цол олгох саналыг өргөн мэдүүлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтан Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.", "2<sup>11</sup> Энэхүү журмын "Дөрөв" дэх хэсгийн 2<sup>1</sup> -т заасны дагуу саналаа өргөн мэдүүлэлгүйгээр дээд офицерыг иргэний байгууллага эсхүл дээд офицерын цолны зэрэглэлгүй албан тушаалд томилсон байвал түүнийг уг албан тушаалд томилогдсон өдрөөс цэргийн жинхэнэ албанаас чөлөөлөх эсхүл цэргийн цолыг нь бууруулах шийдвэрийг Монгол Улсын Ерөнхийлөгч гаргана." гэсэн заалт тус тус нэмэх,

2. Журмын хоёр дахь хэсгийн 2 дахь заалтыг "2. Зэвсэгт хүчний ахлагчийн "дэд ахлагч, сургагч ахлагч, тэргүүн ахлагч", дунд офицерын болон "хурандаа" -гаас бусад ахлах офицерын цолыг Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, Хил Хамгаалах Ерөнхий газрын дарга, Дотоодын цэргийн дарга нар тус тус олгоно.", мөн хэсгийн 4 дэх заалтыг "4. Ахлагчийн "ахлагч, ахлах ахлагч", түрүүч,байлдагчийн цолыг цэргийн нэгтгэл, анги, байгууллагын захирагч, дарга нар олгоно." ; дөрөв дэх хэсгийн 2 дахь заалтыг "2. Монгол Улсын Ерөнхийлөгч дээд офицерын цол бүхий албан тушаалтныг цэргийн жинхэнэ албанаас чөлөөлөх, цэргийн жинхэнэ албанд эргүүлэн авах, тэдний цолыг бууруулах, хасах буюу сэргээн олгох шийдвэр гаргана." гэж тус тус өөрчлөн найруулах,

3. Журмын хоёр дахь хэсгийн 5 дахь заалтын "Зэвсэгт хүчин, бусад цэргийн" гэснийг хасах.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 3 дугаар сарын 3-ны өдөр

Дугаар 55

Улаанбаатар хот

### Авто тээврийн хэрэгслийг үзлэгт оруулах хугацаа, оношлогооны төлбөрийн жишиг батлах тухай

Авто тээврийн тухай хуулийн 5.1.5-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

зөвхөн тооллогод хамруулж байсугай.

1. Авто тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт оруулах хугацаа, оношлогооны төлбөрийн жишигийг хавсралт ёсоор баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР**

2. Шинэ авто тээврийн хэрэгслийг эхний 2 жилд техникийн хяналтын үзлэгт оруулахгүйгээр

**ДЭД БҮТЦИЙН САЙД Б.ЖИГЖИД**

Засгийн газрын 2004 оны 55 дугаар  
тогтоолын хавсралт

**АВТО ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН  
ҮЗЛЭГТ ОРУУЛАХ ХУГАЦАА, ОНОШЛОГОНЫ ТӨЛБӨРИЙН ЖИШИГ**

Тээврийн хэрэгслийн төрөл	Тухайн жилд үзлэгт орох хугацаа /давтамж/	Нэг удаагийн төлбөрийн жишиг /төгрөгөөр/
Суудлын автомашин	1 удаа	10000
Ачааны автомашин	1 удаа	15000
Автобус	1 удаа	15000
Нийтийн тээврийн автобус	2 удаа	15000
Нийтийн тээврийн такси	2 удаа	10000
Трактор, өөрөө явагч механизм	1 удаа	15000
Чиргүүл	1 удаа	5000
Мотоцикль	1 удаа	5000

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2004 оны 3 дугаар  
сарын 3-ны өдөр

Дугаар 56

Улаанбаатар  
хот

Хэлэлцээр батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Хэлэлцээр"-ийг баталсугай.

2003 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр Сөүл хотноо гарын үсэг зурсан "Аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.ЭНХБАЯР**

**ДЭД БҮТЦИЙН  
САЙД**

**Б.ЖИГЖИД**

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2004 оны 3 дугаар  
сарын 3-ны өдөр

Дугаар 57

Улаанбаатар  
хот

Үйл ажиллагааны чиглэл  
батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ  
нь:

1. "Усны шинэтгэл-XXI" үйл ажиллагааны чиглэлийг хавсралт ёсоор баталсугай.

2. "Усны шинэтгэл-XXI" үйл ажиллагааны чиглэлд нийцүүлэн урт, богино хугацааны

төлөвлөгөө, төслүүдийг нарийвчлан боловсруулж хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Байгаль орчны сайд У.Барсболд, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Дэд бүтцийн сайд Б.Жигжид, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг, Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа нарт даалгасугай.

3. Холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас өгсөн чиглэлийн дагуу энэ тогтоолдор баталсан үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд нутаг дэвсгэртээ хур тунадас, үерийн ус хуримтлуулах далан, цөөрөм, хиймэл нуур байгуулах ажлыг нутгийн иргэдийн оролцоотойгоор зохион байгуулах арга хэмжээ авахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. "Усны шинэтгэл-XXI" үйл ажиллагааны чиглэлийн талаар үндэсний радио, телевиз болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн сурталчлах, энэ ажилд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг өргөн оролцуулах ажил зохион байгуулахыг Байгаль орчны сайд У.Барсболд, Радио, телевизийн хэрэг эрхлэх газрын дарга Б.Ганболд нарт үүрэг болгосугай.

5. Ус ихээр хэрэглэдэг бүтээгдэхүүн боловсруулдаг уул уурхайн болон хөдөө аж ахуйн салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудын экомөнежертэй болох санал, санаачлагыг дэмжих, тэдгээрийг мэргэжлийн сургалтад хамруулах арга хэмжээ авч, зардлыг нь Байгаль орчны сайдын төсвийн багцаас сэнхүүжүүлж байхыг Байгаль орчны сайд У.Барсболдод зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**      **Н.ЭНХБАЯР**

**БАЙГАЛЬ ОРЧНЫ  
САЙД**      **У.БАРСБОЛД**

*Засгийн газрын 2004 оны 57 дугаар  
тогтоолын хавсралт*

## "УСНЫ ШИНЭТГЭЛ-XXI" ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

### Нэг, Нийтлэг үндэслэл

Усны нөөц, түүний ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлт, усны нөөцийн хайгуул, судалгааны ажлын өнөөгийн түвшинд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр Монгол Улсын Засгийн газраас ойрын 20 жилд усны талаар явуулах үйл ажиллагаа, усны нөөцийг зохистой ашиглах усны сав газрын менежментийн чиглэлийг тодорхойлоход оршиж байна.

Үйл ажиллагааны чиглэлийн эрхэм зорилго нь усны нөөцийг нэмэгдүүлэх, хүн амыг эрүүл ахуйн чанарын шаардлагад нийцсэн усаар хангах, эрчимжсэн хөдөө аж ахуй, уул уурхайн үйлдвэрлэлийн ус хангамжийг сайжруулж, экологийн тэнцвэрийг алдагдуулахгүйгээр усыг зохистой ашиглах бодлогыг хэрэгжүүлсэнээр иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Энэхүү үйл ажиллагааны чиглэл нь дараахь зорилтуудаар хэрэгжинэ:

1. улсын хил дамжин урсдаг болон дотоодын урсгалтай гол, мөрний усыг хуримтлуулах цогцолборуудыг барьж байгуулах замаар гадаргын усны нөөц, усан хангамжийг нэмэгдүүлж эрчим хүчний эх үүсвэр болгон ашиглах асуудлыг шийдвэрлэх;

2. усалтын системүүдийг барих, өргөтгөх болон сэргээн засварлах замаар усалгаатай газар тариаланг хөгжүүлэх;

3. ундны усны хангамжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ төв, суурин газрын стандартын шаардлага хангахгүй байгаа усыг цэнгэгжүүлэн зөөлрүүлж хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах;

4. Монгол орны газрын доорхи усны эрэл хайгуул, гадаргын болон газрын доорхи усны судалгаа шинжилгээний ажлыг шинэ шатанд гаргах замаар усны нөөцөд тулгуурласан ашиглалтын зүй зохистой менежмент бүхий усны бодлогын шинэтгэлийг хэрэгжүүлэх;

5. орон нутгийн нөөц боллоцоонд тулгуурлан хур тунадас, үерийн урсцацыг хуримтлуулах замаар усан хангамж, газар тариалангийн үйлдвэрлэл, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

### Хоёр, Хэрэгжүүлэх арга хэмжээ

Энэхүү үйл ажиллагааны чиглэлийг 2004-2015 он, 2015-2025 онд хоёр үе шаттайгаар хэрэгжүүлэх бөгөөд тухайн үе шатанд хэрэгжих арга хэмжээний төлөвлөгөөг нарийвчлан боловсруулж хэрэгжүүлнэ.

1 дүгээр зорилтын хүрээнд дараахь цогцолборуудыг барьж байгуулна:

№	Усан сан байрлах газар, голын нэр	Олон жилийн дундаж урсац (м <sup>3</sup> /сек)	Илүүдэл урсацаас хуримтлуулах усны хэмжээ (м <sup>3</sup> /сек)	Хоногт хуримтлуулан ашиглаж болох урсацын нөөц (мян.м <sup>3</sup> /хоног)	Усны эзэлхүүн /шоо км (жилээр)/
<b>Нэгдүгээр үе шат 2004-2015 он</b>					
1	Идэр-Тосонцэнгэл	36,40	3,64	314,50	0,114791
2	Завхан-Тайшир	9,13	0,91	78,88	0,028792
3	Туул-Тэрэлж	23,70	3,32	286,68	0,104636
4	Сэлэнгэ-Алтанбулаг	198,00	29,70	2566,08	0,936619
5	Хэрлэн-Говь	28,70	4,31	371,95	0,135762
6	Орхон-Хархорин	7,65	1,15	99,14	0,036188
7	Онон-Дадал	38,20	5,73	495,07	0,180701
8	Ховд-Эрдэнэбүрэн	52,10	3,65	315,10	0,115012
9	Булган-Говь	4,26	0,21	18,40	0,006717
10	Туул-Говь	28,00	1,40	120,96	0,044150
11	Халхгол-Мэнэн	5,72	0,29	24,71	0,009019
	<b>Нийт</b>				<b>1,712389</b>
<b>Хоёрдугаар үе шат 2015 - 2025 он</b>					
1	Эг-Хантай	78,30	11,75	1014,77	0,370390
2	Орхон-Орхон	32,20	3,22	278,21	0,101546
3	Хархираа-Тариалан	3,00	0,45	38,88	0,014191
4	Түргэн-Түргэн	1,78	0,27	23,07	0,008420
5	Ховд-Өлгий	66,60	4,66	402,80	0,147021
6	Эг-Алаг-Эрдэнэ	43,00	3,01	260,06	0,094923
7	Шишхэд-Рэнчинлхүмбэ	7,20	1,08	93,31	0,034059
8	Ерөө-Ерөө	55,40	5,54	478,66	0,174709
9	Онон-Биндэр	17,20	2,58	222,91	0,081363
10	Хараа-Мандал	10,50	1,58	136,08	0,049669
11	Хараа-Түнхэл	10,40	1,56	134,78	0,049196
12	Урд Тамир-Цэцэрлэг	7,50	1,13	97,20	0,035478
13	Богд-Улиастай	4,80	0,72	62,21	0,022706
	<b>Нийт</b>			<b>7934,41</b>	<b>1,183672</b>

2 дугаар зорилтын хүрээнд дараахь услалтын системүүдийг барих, өргөтгөх болон сэргээн

засварлах арга хэмжээ авна:

№	Аймаг	Сум	Услалтын системийн нэр	Хүчин чадал, га-гаар	Хайгуул, судалгаа хийж зураг төсөл боловсруулах		Барьж байгуулан ашиглалтад оруулах	
					Хугацаа	Зардал, сая.төг	Хугацаа	Зардал, сая.төг
<b>А. Сэргээн засварлаж шинэчлэх услалтын системүүд</b>								
1	Төв	Жаргалант	Дэлгэр-Уянга	60	-	2004	173,5	
2	Сэлэнгэ	Сант	Цагаантолгой	1000	-	2004	322,0	
3	Дархан-Уул	Орхон	Шарын гол	436	-	2004		
4	Өвөрхангай	Арвайхээр	Дайргын гол	70	-	2004	9,1	
5	Сэлэнгэ	Алтансулаг	Төхөм	50	-	2004		
6	Хэнтий	Дэлгэрхаан	Хэрлэнбаян-Улаан	1000	-	2004	156,0	
7	Булган	Орхон	Шувуутын гол	80	-	2004	89,5	
8	Говь-Алтай	Халиун	Елтон	200	-	2006		
9	Улаанбаатар	Жаргалант	Алушийн ам	175	2003	-	303,0	
10	Увс	Тариалан	Хархираа	1534	-	2004-2006		
11	Төв	Борнуур	Борнуур	500	2003	2004		
12	Төв	Батсүмбэр	Батсүмбэр	436	2004	2006-2007	322,0	
13	Өвөрхангай	Хархорин	Хархорин	3300	2004	2005-2006		
14	Төв	Батсүмбэр	Баянгол	34	2004	2005		
15	Төв	Батсүмбэр	Сөгнөгөр	60	2004	2005	50,0	
16	Төв	Борнуур	Арангат	280	2003	2005		
17	Увс	Давст	Хилэнцэг	150	2004	2005	300,0	
18	Дархан-Уул	Орхон	Бүрэнтолгой	250	-	2006		
19	Төв	Жаргалант	Жаргалант	500	2004	2004-2006		
20	Говь-Алтай	Цогт	Хаяа	400	-	2004		
21	Төв	Алтанбулаг	Бөхөгийн гол	40	2004	2005		
22	Төв	Баянцогт	Дунд-Урт	57	2004	2006	303,0	
23	Увс	Баруунтуруун	Баруунтуруун	1909	2004	2006-2008		

24	Дархан-Уул	Хонгор	Хонгорын гол	201	2004	2006	156,0
25	Булган	Орхон	Шулуутын гол	80	-	2004	89,5
26	Говь-Алтай	Цогт	Шугуй	450			
27	Төв	Баянцандмань	Шарын ам	50	2004	2006	
28	Төв	Баяндэлгэр	Тогосын хоолой	50	2005	2007	
29	Сэлэнгэ	Хулаат	Хулаат	20	2005	2006	9,1
30	Сэлэнгэ	Баянгол	Загдрын гол	80	2004	2005	
31	Сэлэнгэ	Мандал	Зуунхараа-1	400	-	2004	50,0
В.Динээр барих услагын системүүд							
1	Сэлэнгэ	Баянгол	Эрхэт	100	-	2004	155,0
2	Сэлэнгэ	Баянгол	Загдал	20		2004	40,0
3	Сэлэнгэ	Зүүнбүрэн	Мангирт	300		2004	750,0
4	Төв	Жаргалант	Мөндийн үзүүр	20	-	2004	63,8
5	Сэлэнгэ	Хүдэр	Төмөртөн	500	2004	2005	1250,0
6	Увс	Баруунтуруун	Баруунтуруун	2000	2004	2005-2006	5000,0
7	Хэнтий	Баянмөнх	Баянмөнхийн тал	2000	2004	2005-2006	5000,0
8	Сэлэнгэ	Мандал	Төхмийн булаг	60	2004	2005	150,0
9	Булган	Сэлэнгэ	Ингэтийн хөндий	4000	2005	2007-2008	10000,0
10	Сэлэнгэ	Цагаануур	Тийрэгийн хөндий	8000	2005	2007-2008	5000,0
11	Сэлэнгэ	Зүүнбүрэн	Бонгийн тохой	3000	2005	2007-2008	7500,0
12	Дорнод	Баянтүмэн	Дээд Чойбалсан	2000	2006		
13	Булган	Хутаг	Хонгор-Овоо	1500			
14	Сэлэнгэ	Ерөө	Энхтал	1500			
15	Булган	Хутаг	Намангийн өвөр	2500			
16	Хэнтий	Өндөрхаан	Ногоо бригад	1800			
17	Сэлэнгэ	Зүүнбүрэн	Орхон-Сэлэнгийн бэлчир	3000			
18	Хэнтий	Баян-Ардга	Мөхөөрчийн булан	1500			
19	Увс	Хяргас	Бөөргийн эх	1000			



3 дугаар зорилтын хүрээнд дараахь төв, хэмжээ авна:  
суурин газрын усыг цэнгэгжүүлэн зөөлрүүлэх арга

№	Аймагын нэр	п/п	Сумын нэр	Молгийн дундаж агууламж (30мг/л-ээс их)	Хатуулгынг бууруулах шаардлагатай сумд (5.0 мг-ээс/л-ээс их)	Эрдэсжилийг бууруулах шаардлагатай сумд (1000 мг/л-ээс их)	Фторийг бууруулах шаардлагатай сумд (1.5мг/л-ээс их)
1	Архангай	1	Хашаат	33,6	4,92	557,4	
		2	Хотонт	37,0	5,0	545,1	
2	Булган	3	Дашинчилэн	34,9	5,4	707,8	
		4	Гурванбулаг	34,7	5,6	698,6	
3	Завхан	5	Цагаанчулуут	33,6	6,2	556,9	
		6	Тэлмэн	32,1	6,8	623,9	
		7	Тосонцэнгэл	34,2	3,6	423,9	
		8	Эрдэнэхайрхан	37,5	5,5	804,5	
		9	Завханмандал	42,2	6,8	926,0	
		10	Ургамал	51,2	7,0	881,0	
4	Сэлэнгэ	11	Орхонтуул	34,9	5,0	779,1	
		12	Сүхбаатар хот	38,8	5,5	553,3	
5	Өвөрхангай	13	Нарийнтээл	32,8	5,6	588,9	
		14	Баян-Өндөр	34,9	6,1	629,1	
		15	Богд	40	6,6	1157,6	
		16	Төгрөг	34,3	7,6	1097,0	
		17	Баруунбаян-Улаан	32,7	5,9	1383,4	
		18	Гучин-Ус	-	4,9	1334,4	
6	Хэнтий	19	Баян-Адарга	40,2	6,1	674,7	
		20	Галшар	40,5	5,9	641,5	
		21	Дархан	44,6	6,0	765,4	
7	Баянхонгор	22	Хүрээмарал	43,9	7,7	1009,3	
		23	Баянбулаг	36,2	6,97	757,2	
		24	Заг	101,2	12,84	1908,0	
		25	Галуут	34,7	6,3	481,6	
		26	Бөмбөгөр	46,9	7,81	968,7	
		27	Баян-Овоо	116,7	13,76	1231,7	
		28	Баянлиг	41,7	6,9	1165,1	

		31	Шинэжинст	72,8	8,97	1063,5	
		32	Баацагаан	48,2	6,98	1146,1	
		33	Гурванбулаг	-	5,0	1076,0	
		34	Байдраг	-	4,6	1664,7	
8	Увс	35	Наранбулаг	38,5	7,6	1890,6	
		36	Хяргас	33,5	4,7	674,9	
		37	Тариалан	75,3	4,8	774,6	
		38	Өндөрхангай	-	7,0	1054,0	
9	Төв	39	Заамар	60,7	5,9	733,0	
		40	Өндөрширээт	36,3	4,8	514,0	
10	Баян-Өлгий	41	Дэлүүн	58,3	6,8	806,0	
		42	Толбо	39,7	5,5	609,9	
		43	Сагсай	45,0	5,2	432,4	
		44	Бугат	31,5	5,5	507,6	
		45	Ногооннуур	31,5	5,5	471,9	
		46	Улаанхус	70,0	9,8	872,0	
11	Говь-Алтай	47	Дарви	45,7	7,7	844,7	
		48	Төгрөг	62,8	8,24	828,6	
		49	Халиун	37,3	5,4	725,8	
		50	Чандмань	65,3	9,0	1368,7	
		51	Баян-Уул	43,8	6,2	900,0	
		52	Алтай хот	69,3	7,4	725,1	
		53	Дэлгэр	31,9	6,5	786,8	
		54	Жаргалан	42,5	6,4	790,4	
		55	Шарга	48,3	6,3	739,0	
		56	Хөхморьт	38,6	5,9	909,9	
		57	Эрдэнэ	118	16,9	2373,7	
		58	Цогт	38,5	7,3	747,2	
		59	Бигэр	-	8,7	790,8	
		60	Тонхил	-	7,3	528,3	
12	Дорнод	61	Дашбалбар	33,7	4,9	596,1	
		62	Эрээнцав	59,3	9,3	1270,9	
		63	Баян-Уул				2,66
		64	Чойбалсан				3,42



		65	Булган	35,6	5,3	777,9	
		66	Халхгол	57,1	7,6	1107,7	
		67	Сүмбэр	54,0	4,8	1418,8	
		68	Баянтүмэн	-	4,4	1076,7	2,33
		69	Хэрлэн	34,1	5,5	1521,6	
		70	Сэргэлэн	-	4,7	741,2	2,43
		71	Цагаан-Овоо	36,9	6,1	1179,9	3,04
13	Сүхбаатар	72	Баяндэлгэр	41,5	7,0	1392,7	3,54
		73	Түвшинширээ	35,9	5,6	1235,5	
		74	Бүрэнцогт	84,5	9,3	1444,9	
		75	Сүхбаатар	47,5	6,1	1290,1	3,72
		76	Халзан	43,0	6,6	1505,7	2,35
		77	Асгат	49,3	7,3	1198,9	2,35
		78	Эрдэнэцагаан	35,3	5,1	1044,4	5,45
		79	Дарьганга	76,9	7,2	1057,2	
		80	Наран	45,7	5,8	1750,9	2,05
		81	Онгон	34,3	5,2	1763,2	
		82	Баруун-Урт хот	45,6	5,2	1035,4	2,45
		83	Уулбаян	-	4,8	1191,1	1,9
		84	Түмэнцогт				
14	Дундговь	85	Дэлгэрцогт	48,2	7,6	1112,6	
		86	Дэрэн	43,7	5,8	1255,4	
		87	Цагаандэлгэр	116,4	14,5	1994,6	
		88	Эрдэнэдалай	31,5	4,7	1166,4	
		89	Луус	44,2	6,0	2922,3	
		90	Баянжаргалан	34,7	5,5	1191,7	
		91	Өлзийт	44,0	5,84	1441,5	
		92	Гурвансайхан	85,2	11,3	1459,5	
		93	Дэлгэрхангай	-	4,7	1177,0	
15	Дорноговь	94	Сүмбэр	63,2	9,6	1414,7	
		95	Даланжаргалан	95,0	11,47	2638,2	3,61
		96	Хажуу-Улаан	56,9	7,8	1148,1	
		97	Дэлгэрэх	38,7	6,2	1513,8	
		98	Хар-Айраг	45,1	6,2	1432,5	1,81
		99	Айраг	32,2	5,3	2189,6	

	100	Хатанбулаг	54,3	8,5	2035,0	1,94
	101	Сулинхээр	56,1	8,6	1760,9	
	102	Эрдэнэ	40,8	7,4	2236,3	
	103	Улаанбадрах	44,9	7,88	1573,5	2,25
	104	Алтанширээ	39,7	4,6	1344,6	
	105	Хөвсгөл	-	5,0	1122,8	
	106	Өргөн	-	4,8	1290,5	2,07
	107	Иххэт				2,5
	108	Зүүнбаян				1,52
	109	Сайншанд				2,15
	110	Сайхандулаан	-	5,6	1378,3	
16	Ховд	111 Дөргөн	63,4	14,8	1894,5	
		112 Дарви	35,2	6,77	703,6	
		113 Дуут	-			
17	Өмнөговь	114 Булган	34,6	5,1	541,5	1,65
		115 Сэврэй	30,4	5,2	3596,1	
		116 Цогтцэций	-	3,9	1243,9	
		117 Цогт-Овоо		4,4	1116,4	
		118 Хүрмэн	-	5,2	1216,9	
		119 Ноён	30,1	6,3	1269,0	

4 дүгээр зорилтын хүрээнд газрын доорхи судалгааны ажлын чиглэлээр дараахь арга хэмжээг усны эрэл хайгуул, гадаргын ба газрын доорхи усны хэрэгжүүлнэ:

Д/л	Ажлын нэр	Үнэлэх нөөц, м. куб/хоног, хамруулах талбай	Санхүүжилт
1	Эдийн засгийн хөгжлийн бүс нутгуудад 1:100000, 1:200000-ын масштабын экологи, гидрогеологийн төрөлжсөн зураглал хийх	Монгол орны нутаг дэвсгэрийн 40 хүртэлх хувийг хамруулах	Улсын төсөв
2	Монгол орны 1:500000-ын масштабын гидрогеологийн зургийг хэвлүүлэх		Улсын төсөв
3	Усны нэгдсэн мэдээллийн санг монгол орны гадаргын, газрын доорхи усны болон ус ашиглалт, хамгаалалтын, усны барилга байгууламжийн, усны эрчим хүчний гэх зэргээр төрөлжүүлэн газар зүйн мэдээллийн систем /GIS/-д тунгуурлан хийж байнга баяжуулж байх		Хандивлагч орнуудын дэмжлэгээр
4	Усны сав газрын нэгдсэн менежментийн загвар төслийг боловсруулан хэрэгжүүлэх		Хандивлагч орнуудын дэмжлэгээр
5	Ус хангамжийн эх үүсвэрийг илрүүлж үнэлэх газар доорхи усны эрэл хайгуулын ажлыг гүйцэтгэх:		Улсын төсөв

а/Хот суурин:		
Улаанбаатар	100000	Улсын төсөв
Эрдэнэт	10000	Улсын төсөв
Алтанбулаг	6000	Улсын төсөв
Замын-Үүд	10000	Улсын төсөв
Хархорин	80000	Улсын төсөв
Мандалговь	4000	Улсын төсөв
Дорноговь	52000	Улсын төсөв
Ховд	8000-12000	Улсын төсөв
Улиастай	8000-12000	Улсын төсөв
Зуунмод	8000-12000	Улсын төсөв
Дархан	8000-12000	Улсын төсөв
Өндөрхаан	8000-12000	Улсын төсөв
Чойбалсан	8000-12000	Улсын төсөв
Аймгийн төвүүдийн усны эх үүсвэрийн нөөц үнэлгээг 2010 оноос цааших хугацаанд үргэлжлүүлэн хийх	4000-8000	Улсын болон орон нутгийн төсөв
Сумын төв, жижиг суурингийн ус хангамжийн судалгаа хийх	200-1200 /30 төв, суурин газар/	Орон нутгийн төсөв
б/Уулын үйлдвэр:		
Оюутолгой	Захиалга тодорхойгүй	Хувийн хөрөнгө оруулалт
Төмөртэй-Овоо		Хувийн хөрөнгө оруулалт
Бүрэнхаан		Хувийн хөрөнгө оруулалт
Цагаансуварга		Хувийн хөрөнгө оруулалт
Тавт		Хувийн хөрөнгө оруулалт
Цав		Хувийн хөрөнгө оруулалт
Усалгаатай тариалан зэрэг ус хэрэглэгчдийн захиалгаар гүйцэтгэх ажил		Хувийн хөрөнгө оруулалт
6. Рашаан, термаль усны судалгаа хийх		Улсын төсөв
7. Мөстөл судлалын өртөөг Монгол Алтай, Цамбагаравт шинээр байгуулах		Улсын төсөв
8. Гадаргын болон газрын доорхи усны горимын мониторингийн сүлжээг өргөтгөн зохион байгуулах		Улсын төсөв

5 дугаар зорилтын хүрээнд аймаг, нийслэл, сум, дүүрэг, багийн иргэд, малчид, тариаланчидтай тухайн газар орны онцлог, хур тунадас, үерийн усыг хуримтлуулж нөөцийг нэмэгдүүлэх асуудлаар санал солилцож, судалгаа хийх замаар газар тариалан, эрчимжсэн мал ахуй эрхлэдэг иргэд, аж ахуйн нэгжийн болон бэлчээрийн усан хангамжийг сайжруулахад дэмжлэг үзүүлэхүйц гадаргын усны нөөц бүхий далан барих, хиймэл нуур, хөв, цөөрөм

байгуулах арга хэмжээг орон нутгийн хөрөнгө, хич, нөөц бололцоонд тулгуурлан хэрэгжүүлнэ.

Гурав. Үйл ажиллагааны чиглэлийн үр дүн

1. Гадаргын болон газрын доорхи ус ашиглалтыг тэнцвэржүүлнэ.
2. Гадаргын усны нөөцийг 1,7-2 дахин нэмэгдүүлнэ.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 3 дугаар сарын 3—ны өдөр

Дугаар 58

Улаанбаатар хот

Хэлэлцээр батлах тухай

Олон улсын гэрээний тухай хуулийн 14.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээрийг баталсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

2003 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Стокгольм хотноо гарын үсэг зурсан Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Монгол Улсын Засгийн газар, Шведийн Вант

ГАДААД ХЭРГИЙН  
САЙД

Л.ЭРДЭНЭЧУЛУУН

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 3 дугаар сарын 3—ны өдөр

Дугаар 59

Улаанбаатар хот

Засгийн газрын үйл ажиллагааны мэдээлэл, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх тухай

Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

хөрөнгийг санхүүжүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

1. Засгийн газрын бодлого, шийдвэрийг мэдээлэх, сурталчлах ажлыг Монголын сонинь холбоо, Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлээр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан ажиллахыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ө.Энхтүвшинд зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу гүйцэтгүүлэх ажилд шаардагдах

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН  
САЙД

Ч.УЛААН



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 3 дугаар сарын 11-ний өдөр

Дугаар 60

Улаанбаатар хот

Хэлэлцээрийг батлах тухай

Олон улсын гэрээний тухай хуулийн 14.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Чили Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээрийг баталсугай.

Сантьяго хотноо 2003 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр гарын үсэг зурсан Монгол Улсын дипломат болон албан паспорт эзэмшигчид, Бүгд Найрамдах Чили Улсын дипломат, албан болон тусгай паспорт эзэмшигчдийг визээс чөлөөлөх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

ГАДААД ХЭРГИЙН  
САЙД

Л.ЭРДЭНЭЧУЛУУН

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 3 дугаар сарын 17-ны өдөр

Дугаар 65

Улаанбаатар хот

Малын гоц халдварт шүлхий өвчний талаар авах зарим арга хэмжээний тухай

Дундговь аймгийн Баянжаргалан, Сүхбаатар аймгийн Баяндэлгэр, Наран сумын нутагт малын гоц халдварт шүлхий өвчин гарсантай холбогдуулан Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 9 дүгээр зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

1. Дундговь аймгийн Баянжаргалан, Өндөршил, Сүхбаатар аймгийн Баяндэлгэр, Наран, Онгон сумын нутаг дэвсгэрт 2004 оны 3 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн хорио цээрийн онцгой дэглэм тогтоон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

3. "Малын гоц халдварт өвчний цагийн байдал, түүнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2004 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 37 дугаар тогтоолын 3-дугаар зүйлийг хэрэгжүүлж ажиллахыг Дундговь аймгийн Засаг дарга Ж.Адъяа, Сүхбаатар аймгийн Засаг дарга Т.Дашсүрэн нарт даалгасугай.

2. Дундговь аймгийн Цагаандэлгэр, Гурвансайхан, Говь-Угтаал, Сүхбаатар аймгийн Түвшинширээ, Уулбаян, Халзан, Дарьганга, Асгат сумын нутаг дэвсгэрт 2004 оны 3 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн хорио цээрийн хязгаарлалтын дэглэм тогтоож нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг гамшгаас хамгаалах

4. "Малын гоц халдварт өвчний цагийн байдал, түүнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2004 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 37 дугаар тогтоолын 2 дугаар зүйлээс "... Дундговь аймгийн Өндөршил, Сүхбаатар аймгийн Баяндэлгэр..." гэснийг хассугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

ХҮНС, ХӨДӨӨ АЖ  
АХУЙН САЙД

Д.НАСАНЖАРГАЛ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.  
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэлэлцэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12  
Төрийн ордон

☎ 329612  
Индекс 14003

☎ 329487

Хэвлэлийн хуудас 2